

## Төсөл

# НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үеийн аюулгүй байдалд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2.Үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгч болон ажилтнуудын аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

1.3.Нэг цэгийн үйлчилгээний төв нь MNS ..... Монгол Улсын стандартаар тавигдах шаардлагыг хангасан байна.

1.4.Нэг цэгийн үйлчилгээний төвийн байр нь хүүхэд, эрэгтэй, эмэгтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн хүмүүс байрлах тусгай өрөөнүүдтэй байна.

1.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан үйлчилгээг нэг цэгийн төвөөр үзүүлэх үед тухайн төвийн харьяалах нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагаас хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан аюулын зэргээс шалтгаалж аюулгүй байдлыг хангаж ажиллана.

### Хоёр.Аюулын зэргийг тодорхойлох

2.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь нэг цэгийн үйлчилгээний төвд ирсэн хохирогчийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлнэ.

2.2.Хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулахдаа Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд нарын 2009 оны 128/188 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн хийх, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох үнэлгээг хийх заавар”-ыг баримтлан доор дурдсан эрсдэлийн түвшинг харгалзан үзнэ:

2.2.1.аюулын зэргийн өндөр түвшин: амь насанд нь бодитой заналхийлсэн, бие махбодид хохирол учруулсан, тарчлаасан, байнгын дарамтанд байлгасан, гэмт хэрэг үйлдэхийг тулган шаардсан;

2.2.2.аюулын зэргийн дунд түвшин: айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгисөн, ятгасан, нөлөөлсөн, мөнгө, эд зүйл, албан тушаал амласан;

2.2.3.аюулын зэргийн бага түвшин: хохирогчтой уулзах, харилцаа тогтоохыг оролдсон.

### Гурав.Аюулын зэргийн өндөр түвшний хохирогчид хамгаалалтын арга хэмжээ авах

3.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 34 дүгээр зүйл, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийг үндэслэн хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийг түр хамгаалах байранд хүргүүлнэ.

3.2.Хохирогчид шаардлагатай тохиолдолд Нэг цэгийн үйлчилгээний төв дээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.3-т заасан биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж болно.

### Дөрөв.Аюулын зэргийн дунд түвшний хохирогчид

## хамгаалалтын арга хэмжээ авах

4.1. Шаардлагатай тохиолдолд энэ журмын 3.1-д заасан арга хэмжээг авч болно.

4.2. Нэг цэгийн үйлчилгээний төвд 24 цаг хүртэлх хугацаанд хохирогчид холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

4.3. Аюулын зэрэг арилсан тохиолдолд хохирогчийн хүсэлтийг харгалзан эцэг, эх, асран хамгаалагчид хүлээлгэн өгнө.

### Тав. Аюулын зэргийн бага түвшний хохирогчид үзүүлэх туслалцаа

5.1. Шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрсдэлийн бага түвшний хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулж болох бөгөөд энэ журмын 4.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### Зургаа. Эрх зүйн туслалцаа үзүүлэх

6.1. Эрх зүйн зөвлөгөөг утсаар болон цахим хэлбэрээр үзүүлэх бөгөөд үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл, судалгааг нийгмийн ажилтан хөтөлнө.

6.2. Хохирогчид хууль зүйн зөвлөгөөг үзүүлэхдээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасан үндэслэл, журмын дагуу өмгөөлөгчтэй холбон зуучлах үйлчилгээг нийгмийн ажилтан үзүүлнэ.

### Долоо. Нэг цэгийн үйлчилгээний төвийн байрны аюулгүй байдлыг хангах

7.1. Нэг цэгийн үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хөдөлгөөнт болон явган эргүүлийн чиглэлд тусгаж, хяналтад байлгана.

7.2. Төвийн дотор болон гадна орчныг хянах зорилгоор 24 цагаар телекамерын хяналтад байхаар зохион байгуулна.

7.3. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага харьяаллын дагуу дуудлагаар шуурхай үйлчилж, шаардлагатай тохиолдолд хойшлуулшгүй ажиллагааг явуулна.

7.4. Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журамд зааснаар уулзалт хийх үеийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага хангана.

7.5. Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан нь дараах үүрэгтэй:

7.5.1. үйлчлүүлж байгаа иргэнд хууль тогтоомж, төвийн дотоод журам мөрдөхийг шаардах;

7.5.2. нэг цэгийн үйлчилгээний төвд нэвтрэгсдийн биеийн байцаалт, холбогдох баримт бичгийг шалгаж оруулах;

7.5.3. бусдад хор уршиг учруулж болзошгүй эд зүйл, материал байгаа эсэхийг шалгах;

7.5.4. сэжиг бүхий этгээд, согтуурсан, мансуурсан этгээдийг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авах;

7.5.5. төвийн эд хогшил, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, шаардлагатай үед эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх;

7.5.6. төвөөр үйлчлүүлэгчдийн бүртгэл, тэмдэглэлийг хөтөлж, эрх бүхий албан тушаалтанд танилцуулах;

7.5.7. үйлчлүүлэгчийн болон мэдээллийн аюулгүй байдлын нууцлалыг хангаж, баримт материалыг баталгаатай, аюулгүй газар хадгалах;

7.5.8. үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллийг өгөх.

## Найм. Хориглох зүйл

8.1.Нэг цэгийн үйлчилгээний төвд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.шашин болон улс төрийн үзэл номлолыг сурталчлах;

8.1.2.ашгийн үйл ажиллагаа явуулах.

## Ес. Бусад зүйл

9.1.Журмын хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, холбогдох журам, зааварт санал боловсруулах, биелэлтийг хангах ажиллагаанд цагдаагийн төв байгууллагын Гэмт хэрэгтэй тэмцэх алба хяналт тавьж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ.

9.2.Нэг цэгийн үйлчилгээний төвийн тоо бүртгэл хөтлөх, нэгдсэн мэдээллийн санд хүргэх, тайлан мэдээг гаргахтай холбоотой асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны .... дугаар тушаалаар баталсан “Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-аар зохицуулна.

9.3.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---